



ГАЗАР ЗОХИОН БАЙГУУЛАЛТ,  
ГЕОДЕЗИ, ЗУРАГ ЗҮЙН ГАЗРЫН  
ДАРГЫН ТУШААЛ

2019 оны 12 сарын 19 өдөр

Дугаар А/291

Улаанбаатар хот

Журам батлах тухай

Засгийн газрын агентлагийн эрх зүйн байдлын тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.4 дэх хэсэг, Геодези, зураг зүйн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.8.2, 10 дугаар зүйлийн 10.3, 10.4, 13 дугаар зүйлийн 13.1 дэх хэсэг, Газар зохион байгуулалт, геодези, зураг зүйн газрын даргын дэргэдэх зөвлөлийн 2019 оны 12 дугаар сарын 06-ны өдрийн 17 дугаар хурлын тэмдэглэлийг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. “Геодезийн байнгын цэг, тэмдэгтийг хадгалах, хамгаалах, нүүлгэн шилжүүлэх журам”-ыг хавсралтаар баталсугай.
2. “Геодезийн байнгын цэг, тэмдэгтийг хадгалах, хамгаалах, нүүлгэн шилжүүлэх” журмыг мөрдөж ажиллахыг аймгийн Газрын харилцаа, барилга, хот, байгуулалтын газар, нийслэлийн Газар зохион байгуулалтын албанд, хэрэгжилтийг хангаж, хяналт тавьж ажиллахыг Геодези, зураг зүйн хэлтэс /Д.Мөнхцэцэг/-т тус тус даалгасугай.


ДАРГА



Ц.ГАНХҮҮ

09 192261

Газар зохион байгуулалт, геодези, зураг  
зүйн газрын даргын 2019 оны ... дугаар тушаалын хавсралт



## ГЕОДЕЗИЙН БАЙНГЫН ЦЭГ, ТЭМДЭГТИЙГ ХАДГАЛАХ, ХАМГААЛАХ, НҮҮЛГЭН ШИЛЖҮҮЛЭХ ЖУРАМ

### Нэг. Нийтлэг үндэслэл

1.1. Энэхүү журмыг “Геодези, зураг зүйн тухай хууль” болон түүнтэй холбогдон гарсан бусад эрх зүйн баримт бичгүүдийн хүрээнд геодезийн байнгын цэг, тэмдэгтийн бүрэн бүтэн байдлыг хадгалах, хамгаалах, бүртгэлжүүлэх, сэргээн засварлах, нүүлгэн шилжүүлэх зөвшөөрөл олгох, мэдээллийн санд бүртгэх, шинэчлэх үйл ажиллагааг зохицуулахад баримтлана.

### Хоёр. Цэг, тэмдэгтийн бүрэн бүтэн байдлыг хадгалах, хамгаалах

2.1. Аймгийн Газрын харилцаа, барилга, хот байгуулалтын газар, сумын газрын даамал болон нийслэл, дүүргийн газар зохион байгуулалтын алба өөрийн харъяалах нутаг дэвсгэртээ байрлах геодезийн байнгын цэг, тэмдэгтийн /цаашид “цэг, тэмдэгт”/ тооллого хийх, цэг, тэмдэгтийн мэдээллийн сангийн шинэчлэлтийг хөтлөх, бүрэн бүтэн байдлыг хадгалах, хамгаалах ажлыг тухайн шатны Засаг даргын тамгын газартай хамтран зохион байгуулна.


2.2. Цэг, тэмдэгтийн ач холбогдол, хэрэглээний талаар орон нутгийн хэвлэл, мэдээллийн хэрэгслээр мэдээлэл түгээх, иргэд, олон нийтэд сурталчилан таниулах, шаардлагатай тохиолдолд анхааруулах самбар байршуулах зэргээр цэг, тэмдэгтийг устгахаас сэргийлэх ажлыг зохион байгуулна.

2.3. Цэг, тэмдэгтийн тооллогыг жил бүр хийх бөгөөд тооллогоор цэгийг хайж олох, бүрэн бүтэн байдалд үзлэг хийх, хэмжилт хийх нөхцөл алдагдсан эсэхийг тодорхойлж, байршлын тойм зураг, мэдээлэлтэй тулгана.

2.4. Цэг, тэмдэгтийн тооллогын үр дүнгээр цэг, тэмдэгтийн мэдээллийн санг шинэчилнэ.

2.5. Тооллогын мэдээлэл үнэн зөв эсэхэд цэг, тэмдэгтийн тооллого хийсэн мэргэжилтэн, этгээд хариуцлага хүлээнэ.

2.6. Цэг, тэмдэгтийн тооллогоор цэгийн дугаар, солбицол зөрсөн тохиолдолд цэгийн төвийн дугаар, бичиглэл уншигдах байдлаар цэгийн фото зургийг авч, тооллогын тайланд хавсаргана.





2.7. Тооллого хийсэн тайланг жил бүрийн 11 дүгээр сарын 25-ны дотор геодезийн асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллагад албан тоотоор хүргүүлнэ.

2.8. Цэг, тэмдэгтийн тооллогын тайланг Геодезийн байнгын цэг, тэмдэгтийн мэдээллийн сангийн давхарга тус бүрээр гаргана.

2.9. Цэг, тэмдэгтийн тооллогын тайланг хавсралтад заасан загвараар гаргана.

2.10. Шаардлагатай тохиолдолд цэг, тэмдэгтийн тооллогыг геодези, зураг зүйн үйлдвэрлэл, үйлчилгээ эрхлэх тусгай зөвшөөрөлтэй хуулийн этгээдээр гүйцэтгүүлэх бөгөөд ажлын даалгаварыг Геодезийн асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллага батална.

**Гурав. Цэг, тэмдэгтийг сэргээн засварлах, нүүлгэн шилжүүлэх зөвшөөрөл олгох**

3.1. Цэг, тэмдэгтийг шилжүүлэн байгуулах, сэргээн засварлах ажлыг аймгийн Газрын харилцаа, барилга, хот байгуулалтын газар болон нийслэл, дүүргийн газар зохион байгуулалтын алба өөрийн харъяалах нутаг дэвсгэртээ зохион байгуулна.


3.2. Цэг, тэмдэгтийг зайлшгүй нүүлгэн шилжүүлэх шаардлага гарсан тохиолдолд геодезийн асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллагаас зөвшөөрөл авна. Зөвшөөрөл авах хүсэлтэд цэг, тэмдэгтийн талаарх мэдээлэл, цэг, тэмдэгтийг нүүлгэн шилжүүлэх шалтгаан, нөхцөлийг /барилга байгууламж барих, уул уурхайг ашиглах, газар тариалан тарих гм/ тодорхой бичнэ. Мөн хүсэлт гаргасан хуулийн этгээд, иргэний хүсэлтийг хавсаргана.

3.3. Зөвшөөрөл олгосон бичигт шилжүүлэн байгуулах тухайн цэгийн талаарх дэлгэрэнгүй мэдээлэл, шилжүүлэн байгуулах ажлын даалгавар, төсвийн тооцооны хамт хүргүүлнэ.

3.4. Цэг, тэмдэгт устгасан, эвдэрч гэмтсэн тохиолдолд устсан шалтгааныг тодорхойлж, буруутай иргэн, хуулийн этгээдээр сэргээн засварлах зардлыг гаргуулна.

3.5. Цэг, тэмдэгтийг шилжүүлэн байгуулах, сэргээн засварлах зардлыг “Геодези, зураг зүйн ажлын жишиг үнэ” /БД81-103-13/ барилгын дүрмийг баримтлан тооцно.

3.6. Шинээр суулгах геодезийн цэгийн байршлыг газар оронд хайгуул хийж, геодезийн зорилгоор цаашид удаан хугацаанд ашиглах бололцоо нөхцөлийг судлан тогтооно.



3.7. Цэг, тэмдэгтийг “Геодезийн байнгын цэг, тэмдэгт байгуулах” /БД 11-104-19/ барилгын дүрмийг баримтлан байгуулна.

3.8. Геодезийн байнгын цэг, тэмдэгтийг шилжүүлэн байгуулах, сэргээн засварлах ажлыг Геодези, зураг зүйн үйлдвэрлэл, үйлчилгээ эрхлэх хуулийн этгээд гүйцэтгэнэ.

3.9. Шинээр байгуулсан цэгийн солбицол, өндөр, хүндийн хүчний хурдатгалын утгыг тогтоохдоо Монгол улсын Засгийн газрын 2009 оны 25 дугаар тогтоол, ГХГЗЗГ-ын даргын 2014 оны 4-р сарын 10-ны өдрийн А/112 дугаар тушаал, ГХГЗЗГ-ын даргын 2014 оны 10-р сарын 03-ны өдрийн А/261 дугаар тушаал, “Хиймэл дагуул (GPS/ГЛОНАСС)-ын технологиор Монгол улсын геодезийн сүлжээ байгуулах үндсэн дүрэм” /БнБД 14-101-08/, “Өндрийн I, II ангийн сүлжээний тэгшитгэн бодолтын ажил” /БД 11-107-16/ барилгын дүрэм, “Монгол Улсын өндрийн I ба II ангийн сүлжээ байгуулах үндсэн дүрэм” /БнБД 11-09-16/ барилгын норм ба дүрэм, “Өндрийн III ба IV ангийн сүлжээ байгуулах” /БД 11-121-19/ барилгын дүрэм, “Монгол Улсын гравиметрийн тулгуур сүлжээ байгуулах дүрэм” /БнБД 11-10-17/ барилгын норм ба дүрэм зэрэг норм, дүрмийг баримтлана.


3.10. Геодезийн байнгын цэг, тэмдэгтийн төвийг газарт бэхэлж, суулгасны дараа цэгийн хувийн хэргийг “Геодезийн байнгын цэг, тэмдэгт байгуулах” /БД 11-104-19/ барилгын дүрмийн Хавсралт 2-ын дагуу шинээр хөтөлж, мөн дүрмийн Хавсралт 3-ын дагуу төрийн хамгаалалтанд актаар хүлээлгэн өгнө.

3.11. Аймгийн Газрын харилцаа, барилга, хот байгуулалтын газрын геодези, зураг зүйн асуудал хариуцсан мэргэжилтэн, сумын газрын даамал болон нийслэл, дүүргийн Газар зохион байгуулалтын албаны геодези, зураг зүйн асуудал хариуцсан мэргэжилтэн шинээр байгуулсан цэгийг актаар хүлээн авч, цэгийг шилжүүлэн байгуулж, сэргээн засварласан ажлын тайланг Геодезийн асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллагад хүргүүлж, мэдээллийн санд өөрчлөлт, шинэчлэлтийг хөтөлнө.

#### **Дөрөв. Цэг, тэмдэгтийг бүртгэлжүүлэх, мэдээллийн сангийн шинэчлэлт, өөрчлөлтийг хөтөлөх**

4.1. Цэг, тэмдэгтийн мэдээллийн санг бүртгэх, хөтлөхөд ГЗБГЗЗГ-ын 2018 оны А/166 дугаар тушаалаар баталсан геодезийн байнгын цэг, тэмдэгтийн мэдээллийн сангийн загварыг баримтлана.

4.2. Аймгийн Газрын харилцаа, барилга, хот байгуулалтын газар болон нийслэлийн Газар зохион байгуулалтын албаны геодези, зураг зүйн асуудал







103

### Хавсралт. Цэг, тэмдэгтийн тооллогын тайлангийн загвар

Давхаргын нэр	Аймаг, нийслэлийн нэр	Сум, дүүргийн нэр	Цэгийн дахин давтагдашгүй дугаар	Цэгийн дугаар	Цэгийн нэр	В /өргөрөг/	L /уртраг/	Тайлбар
1	2	3	4	5	6	7	8	9

УРСН БАЙГУУЛАЛТ  
ТӨСВИЙН ЗУРАГ ЗҮГНЭГЭЭР  
**ЭХ ХУВЬ**  
Гушөөн #1091